



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/135/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд хот

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Аудитын менежер:

Утас:70523020

Цахим хаяг: DORNOGOVI@AUDIT.COM

Ц.Лүндэгмаа

Цахим хаяг: Lundegmaa.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

## Агуулга

---

Аудитын тайлан.....	5
1.1 Оршил.....	5
1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
1.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
1.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
1.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
1.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
1.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
1.11 Шилэн дансны мэдээлэл .....	10
1.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
1.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
2 Менежментийн захидал .....	11
2.1 Зардлын данстай холбоотой.....	11

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 44303 Дорноговь аймаг, Сайвандуу сум, 3 дугаар баг, Улаан дугуйн замын III байр, Утас: 17079 2 23-34	<b>МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА М.МӨНХБАЯР ТАНАА</b>
2019-02-20 № 1-6/113 өмчийг _____ -ны № _____ -т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Зөрчилгүй санал дүгнэлт</b>	
<p>Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газрын нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	

**Үүрэг, хариуцлага**

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.АРИУНАА

## **АУДИТЫН ТАЙЛАН**

### **1.1 Оршил**

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дарга М.Мөнхбаяр-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019-02-11-наас 2019-02-14-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019-02-15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019-01-25-ны өдрийн 115 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **1.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь “Сахилга хариуцлагыг дээшлүүлэх, өөрчлөлтийг өөрөөсөө” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хэрэглэгч, бизнес эрхлэгч олон нийтийн хамтын хяналтыг бэхжүүлэх замаар хүний амь нас, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлээс бодитоор урьдчилан сэргийлж эрсдэлийг бууруулна.
- Нээлттэй байдлыг ханган, цахим үйлчилгээг хөгжүүлж хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Нийт албан хаагчдын мэдлэг, ур чадвар, санаачлага, сахилга хариуцлагыг дээшлүүлж, өөрийгөө өөрчлөх хандлагыг төлөвшүүлнэ.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант онд байгууллагын бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй байна.

#### **1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцээгүй байна.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Emerald” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад

дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### **1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардалыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгөөс материаллаг байдлын түвшинг тогтооход бага гарч байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс тогтоов.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018 оны нийт зардал 6,588.87 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 6,588.87 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцов.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### **1.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1620.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	1620.0	

### 1.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 1.8.1.1 Хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой асуудал

Барилга байгууламжийн дахин үнэлгээг 1492.2 мянган төгрөгөөр дутуу үнэлэн санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн аудитын батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан “Хөрөнгийн дахин үнэлгээ хийх аргачлал”-ыг тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** Аудитаар дээрх хөрөнгийн үнэлгээг санхүүгийн тайланд залруулан бүртгэсэн.

### 1.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй.

### 1.10 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 560,370.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 538,474.8 мянган төгрөг буюу 96.1 хуьтай байгаа нь орон тоо дутуу ажилласантай холбоотой цалин хөлс, НДШ-ийн зардал нийт дүнгээр 21.4 сая төгрөгөөр хэмнэгдэж үлдэгдлийг төвлөрүүлжээ.

#### **1.11 Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны цахим сайтанд нэвтрэхэд алдаа үүссэн тул тус байгууллагын шилэн дансанд оруулсан мэдээллийг шалгах боломжгүй байна.

#### **1.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 12 сарын 31-ээр 1/695 албан тоотоор ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **1.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## **2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **2.1 ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ**

#### **2.1.1 Илрүүлэлт**

Байгууллагын дарга 2018 оны 01 дүгээр сарын Б/01 тоот тушаалаар жижүүр ажилтай Ж.Мөнхцэцэгийг няравын ажлыг хавсран гүйцэтгүүлэх шийдвэрийг гаргасан байна. Няравын ажлыг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 30 хувиар тооцож нийт 1620.0 мянган төгрөгийн нэмэгдлийг тайлант хугацаанд олгожээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **2.1.2 Өгсөн зөвлөмж**

Батлагдсан орон тооны хязгаарт багтаан ажилчдын цалин хөлсийг тогтоох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 12 сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 3. Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>31,637,901.59</b>	<b>34,332,433.34</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2,174,129.00	15,400.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	679,394.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,494,735.00	15,400.00
3351	Байгууллагаас авах авлага	315,400.00	15,400.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,179,335.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	29,463,772.59	34,317,033.34
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	10,625,048.45	8,709,107.60
35110	Тусгай зориулалттай материал	00.00	00.00
35130	Эм боох материал	10,625,048.45	8,709,107.60
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	18,838,724.14	25,607,925.74
35410	Бичиг хэргийн материал	3,008,366.17	2,845,712.77
35420	Аж ахуйн материал	14,525,986.97	20,141,821.97
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	112,000.00	1,481,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,192,371.00	1,139,391.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>140,789,944.40</b>	<b>384,182,250.03</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>140,789,944.40</b>	<b>384,182,250.03</b>
391	Газар	00.00	00.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>140,789,944.40</b>	<b>353,606,250.03</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	93,126,538.00	262,235,817.45
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26,091,436.03	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	114,780,000.00	145,430,100.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-103,500,221.48	-110,297,671.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	231,726,575.86	258,616,445.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-175,303,522.38	-205,569,363.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,672,435.30	31,672,435.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,620,424.87	-28,481,513.96
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	30,576,000.00
39301	Програм хангамж	913,000.00	913,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-913,000.00	-913,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	30,576,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>172,427,845.99</b>	<b>418,514,683.37</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,624,714.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,624,714.00</b>	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,624,714.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,624,714.00	
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>170,803,131.99</b>	<b>418,514,683.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	170,803,131.99	418,514,683.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	236,449,139.22	267,025,139.22
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-70,700,465.23	-50,250,255.88
51210	Өмнөх үеийн үр дүн	-63,664,313.16	-70,700,465.23
51220	Тайлант үеийн үр дүн	-7,036,152.07	20,450,209.35
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,054,458.00	201,739,800.03
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>172,427,845.99</b>	<b>418,514,683.37</b>

### 3.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>556,589,987.58</b>	<b>679,337,610.83</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>49,413,105.58</b>	<b>116,966,810.83</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>49,413,105.58</b>	<b>116,966,810.83</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	49,243,105.58	116,966,810.83
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,299,000.00	76,299,610.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	254,399.83
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	36,944,105.58	40,412,801.00
120009	Бусад орлого	170,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>507,176,882.00</b>	<b>562,370,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	497,720,000.00	560,370,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	497,720,000.00	560,370,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	940,150.00	2,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	840,150.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00	2,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	8,516,732.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,516,732.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>563,626,139.65</b>	<b>658,887,401.48</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>563,626,139.65</b>	<b>658,887,401.48</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	492,344,130.65	558,688,097.48
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	345,927,770.00	365,824,313.00
210101	Үндсэн цалин	286,249,670.00	283,727,513.00
210102	Нэмэгдэл	21,994,400.00	45,565,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,520,000.00	15,708,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,163,700.00	20,823,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	38,896,663.00	45,037,206.83
210201	Тэтгэврийн даатгал	25,104,366.00	30,196,723.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,802,047.00	4,075,292.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,545,727.00	2,952,051.52
210204	Ажилгүйдлийн даатгал	676,803.00	710,285.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,767,720.00	7,102,855.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,501,200.00	24,982,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,072,999.00	4,530,904.00
210302	Түлш, халаалт	13,391,215.00	13,809,389.00
210303	Цэвэр, бохир ус	3,356,986.00	4,784,007.00
210304	Байрны түрээс	1,680,000.00	1,858,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,220,234.96	36,836,967.00
210401	Бичиг хэрэг	3,574,683.98	5,227,925.00
210402	Тээвэр, шатахуун	12,916,178.87	17,385,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,222,154.00	6,673,946.00
210404	Ном, хэвлэл	00.00	52,980.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,507,218.11	7,257,116.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	8,053,923.84	14,131,240.85
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,943,923.84	12,787,260.85
210502	Хоол, хүнс	2,110,000.00	1,343,980.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,032,835.00	7,008,195.00
210604	Урсгал засвар	1,032,835.00	7,008,195.00
<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	8,005,990.00	14,471,245.00
210702	Дотоод албан томиллолт	8,005,990.00	14,471,245.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,874,068.00	6,164,935.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,862,558.00	800,000.00

Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	267,450.00	859,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,460.00	87,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	867,600.00	2,181,400.00
210807	Газрын төлбөр	50,000.00	49,582.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>46,831,445.85</b>	<b>44,231,494.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	190,800.00	2,822,488.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,640,645.85	41,409,006.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>71,282,009.00</b>	<b>100,199,304.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>56,654,132.00</b>	<b>1,703,685.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,468,700.00	1,703,685.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,968,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,700,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,222,000.00</b>	<b>98,495,619.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,222,000.00	98,495,619.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-7,036,152.07</b>	<b>20,450,209.35</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-7,036,152.07</b>	<b>20,450,209.35</b>

### 3.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>519,398,882.00</b>	<b>638,970,410.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,222,000.00</b>	<b>76,599,610.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	12,222,000.00	76,599,610.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	12,052,000.00	76,599,610.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,052,000.00	76,599,610.00
120009	Бусад орлого	170,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>507,176,882.00</b>	<b>562,370,800.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	497,720,000.00	560,370,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	940,150.00	2,000,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	840,150.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	100,000.00	2,000,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	8,516,732.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,516,732.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>519,398,882.00</b>	<b>615,970,440.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>519,398,882.00</b>	<b>615,970,440.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>448,116,873.00</b>	<b>515,771,136.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	345,722,305.00	365,535,960.00
210101	Үндсэн цалин	286,044,205.00	283,438,160.00
210102	Нэмэгдэл	21,994,400.00	45,566,200.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,520,000.00	15,708,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,163,700.00	20,823,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,761,382.00	45,117,130.00
210201	Тэтгэврийн даатгал	24,275,915.00	30,259,815.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,739,830.00	3,807,616.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,467,955.00	2,869,787.00
210204	Ажилгүйдлийн даатгал	661,635.00	742,710.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,616,047.00	7,437,202.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	20,501,200.00	24,982,500.00
210301	Гэрэл, цахилгаан	2,072,999.00	4,530,904.00
210302	Түлш, халаалт	13,391,215.00	13,809,389.00
210303	Цэвэр, бохир ус	3,356,986.00	4,784,007.00
210304	Байрны түрээс	1,680,000.00	1,858,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,216,392.00	32,402,761.00
210401	Бичиг хэрэг	3,062,122.00	4,629,040.00
210402	Тээвэр, шатахуун	12,205,150.00	18,789,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,270,853.00	6,673,946.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	00.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	678,267.00	2,070,775.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	9,856,950.00	11,066,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,736,950.00	9,503,820.00
210502	Хоол, хүнс	2,120,000.00	1,562,180.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,840,311.00	12,799,520.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	5,800,000.00
210604	Урсгал засвар	1,840,311.00	6,999,520.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,969,990.00	14,471,245.00
210702	Дотоод албан томилолт	7,969,990.00	14,471,245.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,770,743.00	6,421,632.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,792,933.00	800,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	859,450.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,910.00	97,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	839,900.00	2,569,400.00
210807	Газрын төлбөр	50,000.00	49,582.00

Мэргэжлийн хяналтын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,200,000.00	1,685,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	477,600.00	2,974,388.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	477,600.00	2,974,388.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>71,282,009.00</b>	<b>100,199,304.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	56,654,132.00	1,703,685.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	8,516,732.00	00.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,468,700.00	1,703,685.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	34,968,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,700,000.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	12,222,000.00	98,495,619.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,222,000.00	98,495,619.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>22,999,970.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>22,999,970.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	22,999,970.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-22,999,970.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

### 3.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	236,449,139.22	5,054,458.00	-63,664,313.16	177,839,284.06
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>236,449,139.22</b>	<b>5,054,458.00</b>	<b>-63,664,313.16</b>	177,839,284.06
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,036,152.07	-7,036,152.07
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>236,449,139.22</b>	<b>5,054,458.00</b>	<b>-70,700,465.23</b>	170,803,131.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>236,449,139.22</b>	<b>5,054,458.00</b>	<b>-70,700,465.23</b>	170,803,131.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	196,685,342.03	00.00	196,685,342.03
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	30,576,000.00	00.00	20,450,209.35	51,026,209.35
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>267,025,139.22</b>	<b>201,739,800.03</b>	<b>-50,250,255.88</b>	<b>418,514,683.37</b>

### 3.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	560,370,800.00	538,474,791.00	21,896,009.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	560,370,800.00	538,474,791.00	21,896,009.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	558,360,000.00	536,771,106.00	21,588,894.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	385,757,300.00	365,535,960.00	20,221,340.00
210101	Үндсэн цалин	303,659,500.00	283,438,160.00	20,221,340.00
210102	Нэмэгдэл	45,566,200.00	45,566,200.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,708,000.00	15,708,000.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	20,823,600.00	20,823,600.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	46,290,700.00	45,117,130.00	1,173,570.00
210201	Тэтгэврийн даатгал	30,860,500.00	30,259,815.00	600,685.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,857,500.00	3,807,616.00	49,884.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,086,000.00	2,869,787.00	216,213.00
210204	Ажилгүйдлийн даатгал	771,500.00	742,710.00	28,790.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,715,200.00	7,437,202.00	277,998.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,982,500.00	24,982,500.00	0.00
210301	Гэрэл, цахилгаан	7,782,500.00	4,530,904.00	3,251,596.00
210302	Түлш, халаалт	13,604,500.00	13,809,389.00	-204,889.00
210303	Цэвэр, бохир ус	1,295,500.00	4,784,007.00	-3,488,507.00
210304	Байрны түрээс	2,300,000.00	1,858,200.00	441,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	32,435,200.00	32,402,761.00	32,439.00
210401	Бичиг хэрэг	4,608,100.00	4,629,040.00	-20,940.00
210402	Тээвэр, шатахуун	18,789,700.00	18,789,000.00	700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,742,300.00	6,673,946.00	68,354.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд	2,055,100.00	2,070,775.00	-15,675.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,816,000.00	9,503,820.00	-687,820.00
210502	Хоол, хүнс	2,250,000.00	1,562,180.00	687,820.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	35,799,700.00	35,799,490.00	210.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	23,000,000.00	22,999,970.00	30.00
210604	Урсгал засвар	6,999,700.00	6,999,520.00	180.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	12,480,800.00	12,471,245.00	9,555.00
210702	Дотоод албан томилолт	12,480,800.00	12,471,245.00	9,555.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,570,200.00	6,421,632.00	148,568.00
210803	Даатгалын үйлчилгээ	860,300.00	859,450.00	850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,000.00	97,400.00	122,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	60,000.00	10,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,569,900.00	2,569,400.00	500.00
210807	Газрын төлбөр	50,000.00	49,582.00	418.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх,	1,700,000.00	1,685,800.00	14,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,977,600.00	2,974,388.00	3,212.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,977,600.00	2,974,388.00	3,212.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2010800.00	1703685.00	307,115.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	00.00	00.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,010,800.00	1,703,685.00	307,115.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,010,800.00	1,703,685.00	307,115.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	560,370,800.00	538,474,791.00	21,896,009.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	560,370,800.00	538,474,791.00	21,896,009.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00	0.00

